

МОНОС ХҮНС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 26 ны өдөр

№ 24/10

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59-р зүйлийн 59.3, 59.10, 59.11 дэх заалт, 60-р зүйл, 61-р зүйл, 64-р зүйл, 65-р зүйл, 67-р зүйл, 71-р зүйл, 76-р зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, компанийн дүрмийн 6-р зүйлийн 6.2, 6.3, 6.3.2, 6.16-6.18 дахь заалтууд, 7.1.2, 7.17.3 заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Монос хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 09-р сарын 09-ний Даваа гарагийн 14.00 цагт цахимаар хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох
 - 2.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсөвт тодотгол хийх
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 08-р сарын 16-ны өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид хууль тогтоомжид заасан хугацаанд хүргэсүгэй.
4. Хурлын зарыг тогтоолын Хавсралт №01-р батлан, компанийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 07-р сарын 31, 2024 оны 08-р сарын 15-ны өдрүүдэд олон нийтэд зарлан мэдээлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хуулийн хугацаанд брокер, дилерийн компанид цахим хэлбэрээр хүргүүлэхээр тогтоосугай.
6. Хурлын саналын хуудсыг энэ тогтоолын Хавсралт №02-р батлаж, брокер дилерийн компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд тарааж, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах эцсийн хугацааг 2024 оны 08-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар ТУЗ-ийн дарга Х.Анандыг томилсугай.
8. Хурал зохион байгуулах комиссын даргаар гүйцэтгэх захирал А.Отгондарь, гишүүдээр маркетингийн албаны дарга Н.Дуламсүрэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү нарыг томилсугай.
9. Хурлын тооллогын комиссын даргаар санхүүгийн менежер Э.Амарболд, гишүүдээр бүтээгдэхүүний менежер Ц.Дөлгөөнмайдар, санхүүгийн шинжээч П.Энхбаяр нарыг томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллахыг хурал зохион байгуулах комисс (А.Отгондарь)-т даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Х.АНАНД





2024 оны 07-р сарын 26-ны өдрийн ТУЗ-ийн
хурлын 24/10 тогтоолын Хавсралт № 01

/Хэвлэл, мэдээллийн байгууллагад хүргүүлэх зарын эх/

**МОНОС ХҮНС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Монос хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2024 оны 09-р сарын 09-ний Даваа гарагийн 14:00 цагт цахимаар [/meeting.monosfoods.mn/shareholder/meeting/8/](https://meeting.monosfoods.mn/shareholder/meeting/8/) хуралдах тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг идэвхтэй оролцохыг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2024 оны 08-р сарын 16-ны өдөр

Хурлаар хэлэлцүүлэх асуудал:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсөвт тодотгол хийх

Хуралд цахимаар оролцох боломжгүй, урьдчилан санал өгөх хувьцаа эзэмшигч хурлын материалтай танилцан, саналын хуудсыг бөглөн өөрийн харилцдаг брокер, дилерийн компаниар дамжуулах, эсвэл баталгаат шуудангаар 2024 оны 08-р сарын 31-ний өдрөөс өмнө ирүүлнэ үү.

Утас: 80081138, 99035178

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



**МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр: _____
Регистрийн дугаар: _____
Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг) : _____
Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: _____
Бүртгэсэн брокерийн овог, нэр: _____
Кумулятив санал хураах аргаар өгөх саналын тоо: _____
(эзэмшиж буй хувьцааны тоог 11-ээр үржих)

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс		Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1		
2		
3		
4		
5		
6		
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс		Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
9		
10		

Санал өгөх хуудсыг ашиглах саамж:

- ТУЗ-ийн гишүүнийг сонгох санал хураалтыг КТХ-ын 72.1.3-д заасан кумулятив аргаар хураах ба тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж буй хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг бол ТУЗ 11 гишүүнтэй бол та нийт 1100 (100*11=1100) саналын эрхтэй бөгөөд нийт 1100 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно. Эсвэл нийт 1100 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 500 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 5 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно.
- Саналын хуудсыг илгээхийн өмнө сайтар хянан шалгаад илгээх товчийг дарах ба илгээгдсэн төлөвт орсон хуудсыг засварлах, буцаах боломжгүй тул та илгээхээс өмнө саналаа шалгана уу.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____ / / _____

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүйд тооцсон:

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Тооллогын комиссын дарга: _____

Гишүүд: _____



2024 оны 07-р сарын 26-ны өдрийн ТУЗ-ийн
хурлын 24/10 тогтоолын Хавсралт № 02

МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг) : _____

Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: _____

Бүртгэсэн брокерийн овог, нэр: _____

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Монос хүнс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөвт тодотгол хийх			

Санал авах хуудсыг ашиглах санамж:

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсын санал өгөх хэсгийн өмнөх тэмдгийг (✓) тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн хэсгийг (✓) тэмдгийг дарна.
- Саналын хуудсыг илгээхийн өмнө сайтар хянан шалгаад илгээх товчийг дарах ба илгээгдсэн төлөвт орсон хуудсыг засварлах, буцаах боломжгүй тул та илгээхээс өмнө саналаа шалгана уу.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____ / / _____

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүйд тооцсон:

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Тооллогын комиссын дарга: _____

Гишүүд: _____

СЗХ-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн
377-р тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа
эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	МОНОС ХҮНС ХК
Хаяг:	БГД, 20-р хороо, Сонсголонгийн зам гудамж, 32/3 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2024 оны 09-р сарын 09, 14:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	цахимаар
Хурлын төрөл:	Ээлжит бус
Хурал зарлагч:	ТУЗ
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2024 оны 07-р сарын 26
Олон нийтэд зарлах огноо:	2024 оны 07-р сарын 31
Бүртгэлийн өдөр:	2024 оны 08-р сарын 16
Хурлын баримт бичгийг БДК-д хүргүүлэх огноо:	2024 оны 08-р сарын 20
Хүргүүлсэн огноо:	2024 оны 07-р сарын 29
Хурлын даргын нэр:	ТУЗ -ийн дарга Х.Ананд
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга Э.Амарболд Гишүүд Ц.Дөлгөөнмайдар, П.Энхбаяр
Баримт бичгийн жагсаалт	1. Монос хүнс ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2024-07-26 өдрийн тогтоол 2. ХЭ-ийн хурлын зарын загвар 3. ТУЗ гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга 4. ТУЗ-ийн 2024 оны төсвийн санал 5. ХЭ-ийн хурлын дэг 6. ХЭ-ийн хурлын саналын хуудас 7. ХЭ-ийн хурлаас гарах шийдвэрийн төсөл
Баримт бичгийн хуудасны тоо: хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА



/А.ОТГОНДАРЬ/

2024 оны 07 сарын 26 өдөр